



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/711

Улаанбаатар хот

“Үртсэн шахмал түлшний үйлдвэр”  
ОНӨААТҮГ-ыг татан буулгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Иргэний хуулийн 32 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 47, 2023 оны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ-ыг татан буулгах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг хавсралт ёсоор байгуулсугай.

2. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Ажлын хэсэг (М.Энхболд)-т даалгасугай.

2.1. “Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ-ын эд хөрөнгийг Булган аймагт шилжүүлэх ажлыг зохих журмын дагуу зохион байгуулах;

2.2. Татан буулгаж байгаа тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай холбогдох өр авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, байгууллагын хаалтын балансыг 2023 оны эхний улирлаар гаргах;

2.3. Татан буугдаж байгаа үйлдвэрийн газрын бичиг баримтыг архивлан Нийслэлийн Архивын газарт шилжүүлэх ажлыг зохих журмын дагуу зохион байгуулах.

3. “Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ-ыг татан буулгасантай холбогдуулан үйлдвэрийн газрын өр авлагын асуудлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаяр), Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Наранбаатар)-т тус тус даалгасугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (И.Баатархүү)-т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

Д.СУМЬЯАБАЗАР



1110202937



Нийслэлийн Засаг даргын 2023 оны  
06 сарын 26-ны өдрийн  
... захирамжийн  
хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн  
дарга:

М.Энхболд

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын  
Өмчийн менежментийн хэлтсийн дарга

Гишүүд:

Н.Туул

Нийслэлийн Архивын газрын дарга

С.Эрдэнэсайхан

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны  
Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн  
дарга

Б.Чимэдцэеэ

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын  
Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн

Х.Дарамбазар

“Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ-  
ын захирал

Г.Ариунжаргал

“Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ-  
ын нягтлан бодогч

Нарийн  
бичгийн дарга:

Б.Батаа

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын  
Өмчийн менежментийн хэлтсийн мэргэжилтэн

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БОГООД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАН  
ХОТЫН ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
Х. ДАРАМБААЗАР

1110202931